

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИД НЭР ДЭВШИГЧ МӨНХЦЭЦЭГИЙН ШИНЭБАЯРЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Миний бие Монголын Хуульчдын Холбооны ерөнхийлөгчид сонгогдсоноор Монголын хуульчдын нэр хүнд, үнэлэмжийг өсгөх замаар хуульчдыг олон улсын түвшинд ажиллах, чадварлаг боловсон хүчин болгох асуудалд дээр анхаарал хандуулах бөгөөд дараах таван асуудлын хүрээнд мөрийн хөтөлбөрөө дэвшүүлж байна.

Нэг. Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр

- ❖ Хуульчид хуулийн дагуу ажил үүргээ гүйцэтгэсэнтэй холбоотой нийгмийн сөрөг нөлөөлөл, ажил хэргийн нэр хүндэд халдах үйл явдлыг таслан зогсоож, гишүүдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж ажиллана.
- ❖ Монголын Хуульчдын холбооны дэргэд хуульчдад мэргэжлийн сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг эмч, сэтгэл зүйчдийг ажиллуулана.
- ❖ Шүүх, прокурорын байгууллагын ачааллыг бууруулах, шүүх, прокурорын ажиллах орчин болох хуралдааны танхим, ариун цэврийн өрөө гэх мэт асуудлыг сайжруулахад анхаарал хандуулж ажиллана.

Хоёр. Хуульчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, мэргэшүүлэх чиглэлээр

- ❖ Хуульч бэлтгэх сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэхдээ сургалтын агуулга, хөтөлбөрт нэг бүрчлэн үнэлгээ хийж, шинэчлэн сайжруулах ажлыг олон нийтийн оролцоотой буюу ил тод, шат дараатай зохион байгуулна.
- ❖ Хуульчийн үргэлжилсэн сургалтын агуулгыг хуульчдын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн “заавал” болон “сонгох” 2 төрөлд шилжүүлж, зохион байгуулалтын хувьд хуульчдад хүндрэл чирэгдэлгүй болгоно.
- ❖ Сургалтын агуулгын хувьд эрх зүйн сургалтаас гадна хуульчийн эзэмшвэл зохих ур чадвар хөгжүүлэх, санхүү, эдийн засаг, мэдээллийн технологи, анагаах ухаан зэрэг бусад салбартай уялдсан мэдлэг олгох сургалтын агуулгаар өргөжүүлнэ.
- ❖ Хуульчийн үргэлжилсэн сургалтын сургагч багш нарын нөөц бүрдүүлэлтэд онцгойлон анхаарч, урамшууллын тогтолцоог шинэчилнэ. Сургалт бүрийн дараа үр дүнг үнэлэх үнэлгээг хийж, уг үнэлгээнд тулгуурлан урамшууллын хэмжээг тогтоох замаар үргэлжилсэн сургалтад өрсөлдөөний орчинг бий болгоно.
- ❖ Шинэ хуульчдын сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн мэдлэг, практик чадвар, ёс зүйн зэрэг агуулгатайгаар тусгайлан боловсруулж, хэрэгжүүлнэ. Шинэ хуульчдын заавал судлах багц цагийг тухайлан заана.
- ❖ Шинэ тутам үүсэж буй эрх зүйн харилцаа, нийгмийн хүрээнд болон техник технологийн орчинд гарч буй шинэ үзэгдлийн эрх зүйд үзүүлэх нөлөөлөл, тулгамдсан асуудлын талаар олон улсын мэргэшсэн экспертүүдийн сургалтыг цахим болон биечилсэн хэлбэрээр тогтмол зохион байгуулж хэвшинэ.
- ❖ Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээ, судалгаа, хууль тогтоомжийн санд нэвтэрч, мэдлэг, мэргэшлээ дээшлүүлж, цахимаар хөгжих нөхцөлийг бүрдүүлнэ.

- ❖ Эрх зүйч мэргэжлийн дадлага хийх хугацаанд ур чадвараа нэмэгдүүлэх, сургалтад хамрагдах боломжийг нэмэгдүүлнэ.
- ❖ Гадаад улсын хууль зүйн их, дээд сургуулиуд, хуульчдын болон бусад мэргэжлийн холбоодтой хамтын ажиллагааг шинээр эхлүүлэх, тогтоосон хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана.
- ❖ Гадаад улсын их, дээд сургуулиуд болон сан, холбоод зэрэгтэй хамтарсан магистрын болон богино хугацааны сургалтын тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлж, хуульчид олон улсын түвшинд мэргэшил, мэдлэгээ дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- ❖ Хууль зүйн гадаад хэлний олон түвшинт сургалтыг системтэйгээр урт хугацаанд зохион байгуулна.
- ❖ Олон улсын шүүх, арбитрын байгууллагын үйл ажиллагааны онцлог, журам зэргийн талаарх мэдээлэл өгөх цуврал семинарыг тухайн байгууллагад ажилладаг хуульчдын оролцоотойгоор зохион байгуулна.
- ❖ Олон улсад зохион байгуулагдаж байгаа сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, тэтгэлэгт хөтөлбөрийн мэдээллийг хуульчдад нэгдсэн байдлаар хүргэнэ.

Гурав. Монголын Хуульчдын холбоог бэхжүүлэх чиглэлээр

- ❖ Монголын Хуульчдын холбооны үйл ажиллагааны орлого, зарлагыг шилэн дансны хэлбэрээр нээлттэй, ил тод хөтөлнө. Хуульчийн төлсөн нэг төгрөг бүр үр ашигтай зарцуулагдах ёстой.
- ❖ Монголын Хуульчдын холбоог хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллагын хувьд эрх зүйн байдал, үйл ажиллагааны хараат бус байдал, хүний нөөц, байр, танхимын хувьд бэхжүүлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлнэ.
- ❖ Хуульч шүүгчээр томилогдсон тохиолдолд Хуульчдын холбооны гишүүнчлэлээс түдгэлзэх бус, харин хуульчийн мэргэжлийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, хууль зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэх, хууль зүйн бодлогын болон практик судалгаа хийх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхэд идэвхийлэн оролцох нөхцөлийг бүрдүүлнэ.

Дөрөв. Иргэд, олон нийтийн Хуульчид итгэх итгэл, үнэлэмжийг нэмэгдүүлэх чиглэлээр

- ❖ Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд иргэдийн өмнө тулгамдсан хууль зүйн асуудлаар нэвтрүүлэг, подкаст, шторк, ярилцлага, нийтлэл зэргийг бэлтгэн цаг хугацаа, агуулгын дараалалтайгаар олон нийтэд хүргэнэ.
- ❖ Хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх арга хэмжээг зохион байгуулна.
- ❖ Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гарган шүүхээр шийдвэрлүүлсэн тохиолдолд тодорхой хэмжээгээр урамшуулах, алдаршуулах механизмыг бүрдүүлнэ.
- ❖ Нийтийн ашиг сонирхлыг ноцтой зөрчсөн, олны анхаарлыг татсан асуудлаар иргэд, олон нийтийн дуу хоолой болох, шүүхэд нийтийн ашиг сонирхол болон эрх ашиг нь

хөндөгдсөн бүлгийг төлөөлөн нэхэмжлэл гаргах ажлыг Монголын Хуульчдын холбооноос хэрэгжүүлнэ.

**Тав. Хууль тогтоох ажиллагаанд бодлогын нөлөөлөл үзүүлэх,
хууль зүйн шинжлэх ухааны хөгжилд дэмжлэг үзүүлэх чиглэлээр**

- ❖ Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийг хуульчдын дунд тогтмол зохион байгуулна.
- ❖ Хууль тогтоох үйл ажиллагаанд санал, зөвлөмж хүргүүлэх чиглэлээр чиг үүргийн болон сайн дурын хороодод мэргэшил, арга зүйн туслалцаа үзүүлнэ.
- ❖ Хууль тогтоомжийн төсөл боловсруулах чиглэлээр ажиллах боломжтой мэргэшсэн хуульчдын сан бүрдүүлж, тухайн хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллуулахаар санал болгох, мэргэжлийн шинжээчээр оролцуулна.
- ❖ Хууль тогтоомжийн төсөлд тусгагдсан зохицуулалт нь Үндсэн хуулийн суурь зарчим, эрх зүйн онолд харшилсан, практикт хэрэгжих боломжгүй, бусад хууль тогтоомжтой уялдаа холбоогүй, олон улсын жишигт нийцээгүй зэрэг тохиолдолд хөндлөнгийн шинжилгээг шуурхай хийх, хуульчид, олон нийтийн анхаарлын төвд оруулж хэлэлцүүлэх зэрэг бодлогын хэлэлцүүлгийн орчинг бүрдүүлнэ.
- ❖ Хууль зүйн шинжлэх ухааны эрдэмтдийн цуврал лекц, хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулна.

--000--